



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагаатай холбогдуулан хөрөнгө битүүмжлэх мэдэгдэх хуудас, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, битүүмжлэл цуцлах актын маягтын загварыг баталж, мөрдүүлэх, тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавихыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан ҮТЕГ-ын даргын 2008 оны 220 дугаар тушаалын 1, 4 дүгээр хавсралт, ТЕГ-ын даргын 2014 оны А/26 дугаар тушаалыг хүчингүй болгохыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

**ӨРТЭЙ ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ, ХУРААХ,
ХАДГАЛАХ, ХАМГААЛАХТАЙ ХОЛБОГДОХ
ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өртэй татвар төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, авлага, банкн дахь харилцах данс, биет бус хөрөнгө /цаашид “хөрөнгө” гэх/-ийг битүүмжилж, уг хөрөнгөөс татварын өрийг төлүүлэх харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Татварын улсын байцаагч өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг Татварын ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу тогтооно.

1.3.Татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3-т заасан хугацаанд татвараа бүрэн төлөөгүй, эсхүл татвар төлөгчид мөн хуулийн 55.1.4-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд татварын алба хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл болно.

1.4.Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу татварын өр төлөх хугацааг сунгаж хөнгөлөлт үзүүлсэн хугацаанд битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй.

1.5.Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалах ажиллагааг өртэй татвар төлөгчийн харьяалах Татварын алба хэрэгжүүлэх бөгөөд битүүмжилсэн эсхүл битүүмжлэх хөрөнгө байршиж буй нутаг дэвсгэрийн татварын албанд битүүмжилсэн хөрөнгөөс татварын өрийг барагдуулах ажиллагааг шилжүүлж болно.

1.6.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах буюу хөрөнгө битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.7.Хөрөнгө битүүмжлэх ажиллагаанд Татварын ерөнхий хуулийн 19.3-т заасан нөхцөл үүсэх тохиолдолд цагдаагийн байгууллагын дэмжлэг үзүүлнэ.

Хоёр.Хөрөнгө битүүмжлэх ажиллагаа

2.1.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлсэн байна:

2.1.1.татварын өрийг төлүүлэхээр өртэй татвар төлөгч, өв залгамжлагчид “Татварын нэхэмжлэх” хүргүүлсэн байх;

2.1.2.Татварын ерөнхий хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд өртэй татвар төлөгчид “Урьдчилан нэхэмжлэх хуудас” хүргүүлсэн байх;

2.2.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг түүний өмчлөл, эзэмшилд хамаарах эсэхийг дараах байдлаар тодорхойлно:

2.2.1.хөдлөх хөрөнгө, үнэт цаасны тухайд өртэй татвар төлөгч өмчилдөг байх;

2.2.2.үл хөдлөх эд хөрөнгө, автомашин, агаарын хөлөг, эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эсхүл эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий хөрөнгө, зохиогчийн эрх зэрэг биет бус хөрөнгийн тухайд холбогдох бүртгэлийн байгууллагад өртэй татвар төлөгчийн нэрээр бүртгүүлсэн байх;

2.2.3.бүртгэлгүй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, биет бус хөрөнгийн хувьд эзэмшиж буй бодит байдал, ашиглалтын байдал нь өртэй татвар төлөгчид хамаарах үндэслэлтэй байх;

2.2.4.иргэн, хуулийн этгээдийн хувьцаа эзэмших хувийг дүрэм, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өртэй татвар төлөгчийн нэрээр бүртгэгдсэн байх;

2.2.5.авлагын тухайд зээлийн гэрээ, өрийн бичиг, хадгаламжийн дэвтэр, санхүүгийн тайлан, бусад холбогдох нягтлан бодох бүртгэлийн бичиг баримтад өртэй татвар төлөгчид хамаарах тухай тусгагдсан байх;

2.3.Татвар төлөгчийн нэр дээр бүртгэлгүй хөрөнгийг тодорхойлохдоо энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3-д заасан хөрөнгийн тухайд эзэмшигч, эсхүл хөрөнгийн бүртгэл нь өртэй татвар төлөгчид хамааралгүй байсан ч бүртгэлийн дэвтэр, бичиг баримт, холбогдогч талын нэхэмжлэл зэрэгт үндэслэн дор дурдсан бодит байдал тодорхой бол хөрөнгийг өртэй татвар төлөгчид хамаарах хөрөнгө гэж үзнэ:

2.3.1.хөрөнгө нь худалдах худалдан авах, бэлэглэл, арилжаа, хөрөнгө оруулалт зэргээр өртэй татвар төлөгчид шилжсэн;

2.3.2.татвар төлөгч нь хөрөнгөө хууль бусаар шилжүүлсэн;

2.3.3.энэ журмын 3.3.1, 3.3.2-т зааснаас бусад хэлбэрээр эрх нь өртэй татвар төлөгчид хамаарч байгаа боловч, бүртгэл нь өөр этгээдийн нэр дээр байх;

2.4.Татварын өр хураах зардал, хөрөнгийн хөрвөх чадвар зэргийг харгалзан битүүмжлэх хөрөнгийг татварын алба тогтоох ба татвар төлөгч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд дор дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

2.4.1.гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй байх;

2.4.2.мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар байх;

2.4.3.хадгалах эсхүл хураан авахад хялбар байх;

2.5.Татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх, эсхүл битүүмжилсэн хөрөнгөөс татварын өр гаргуулах ажиллагааг бусад татварын албанд шилжүүлэх бол тухайн татвар төлөгчийн харьяалах татварын албаны дарга тушаалаар хэрэгжүүлнэ.

2.6.Хөрөнгийг битүүмжлэхэд татварын улсын /ахлах/ байцаагч нь битүүмжлэх мэдэгдэх хуудас, тэмдэглэл, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас зэрэг бичиг баримтыг үйлдэнэ.

2.7.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэх татварын улсын /ахлах/ байцаагч гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд 2-5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг тухайн татварын албаны даргын тушаалаар томилно.
/Сангийн яамтай зөвших/

2.8.Татварын алба энэ журмын 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд битүүмжлэх ажиллагааг эхлэх талаар өртэй татвар төлөгчид ажлын 5 өдрийн өмнө мэдэгдлийг биечлэн, шуудангаар, цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.9.Татварын алба өртэй татвар төлөгчийн банкн дахь данс /татварын өрийг үл маргах журмаар гаргуулах/-аас бусад хөрөнгийн битүүмжлэлийг дараах байдлаар гүйцэтгэнэ:

2.9.1.эд хөрөнгө битүүмжлэхдээ өртэй татвар төлөгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, нягтлан бодогч болон хөндлөнгийн гэрчийг байлцуулах;

2.9.2.эд хөрөнгө битүүмжилсэн тухай битүүмжлэх акт үйлдэж, актад өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, байршил, татварын өрд хамаарах хугацаа, татварын төрөл, татвар төлөх хуулийн хугацаа болон хэмжээ, битүүмжилсэн хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, шинж чанар, акт үйлдсэн огноо зэргийг тусгах;

2.9.3.битүүмжилсэн эд хөрөнгийн захиран зарцуулах, хадгалах, хамгаалах, ашиглах нөхцөлийг зааж татварын албаны мэдэлд авах, шаардлагатай бол лацдах, ломбодох, түгжих зэргээр ашиглуулахгүй байх, эсхүл эзэмшигчид ашиглуулах нөхцөлтэйгээр хариуцуулан өгөх;

2.9.4.энэ журмын 2.9.1-д заасан этгээд нь эд хөрөнгө битүүмжлэх үйл явцыг нотлох үүрэг хүлээж битүүмжлэх актад гарын үсэг зурах, татгалзсан тохиолдолд шалтгаанаа дурдсан тайлбарыг актад хавсаргах;

2.10.Битүүмжилсэн эд хөрөнгийг хариуцсан эзэмшигч нь уг эд хөрөнгийг үрэгдүүлэх, худалдах, бусдад шилжүүлэхгүй байх, бүрэн бүтэн байдлыг хангах, татварын албаны зөвшөөрөлгүйгээр лац, ломбо, түгжээг хөдөлгөхгүй байх үүрэг хүлээх бөгөөд уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх талаар танилцуулна.

2.11.Татварын алба дор дурдсан хөрөнгийг битүүмжлэх тохиолдолд хөрөнгийг эзэмшигч эрх бүхий этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ:

2.11.1.барьцааны эрхтэй ба гуравдагч этгээдийн эрхтэй хөрөнгийн битүүмжлэлийн эрх эзэмшигчид;

2.11.2.Иргэний хуулийн 185 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан тэмдэглэл хийгдсэн хөрөнгийн битүүмжлэлийг бүртгэлтэй эрх бүхий этгээдэд;

2.12.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйлдсэн баримт бичгийн мэдээллийг битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэснээс хойш ажлын гурван өдөрт багтаан холбогдох бүртгэлийн байгууллагад мөн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

2.13.Татварын алба өртэй татвар төлөгчийн өмчлөл, эзэмшилд байгаа Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлд зааснаас бусад хөрөнгийг битүүмжилнэ.

2.14.Битүүмжлэх ажиллагааг ажлын цагт багтаан гүйцэтгэнэ.

2.15.Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлд заасан Татварын өр хураах үйл ажиллагаанд үйлдэгдэх баримт бичгийг биечлэн, цахимаар, шуудангаар хүргүүлнэ.

2.16.Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3-т зааснаар мэдэгдлийг гардуулсанд тооцно.

Гурав.Хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаас битүүмжлэх, бэлэн мөнгө хураах

3.1.Агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжөөс бусад хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасанд Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгсэл, мал, гэрийн тэжээвэр амьтан хамаарна.

3.2.Татварын алба хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг битүүмжлэхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлсэн байна:

3.2.1.хөрөнгийг татварын албаны мэдэлд авч, өртэй татвар төлөгчийн захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах арга хэмжээ авах;

3.2.2.хөрөнгө битүүмжлэх акт үйлдэж, хувийг өртэй татвар төлөгчид хүргүүлэх;

3.2.3.өртэй татвар төлөгчийн гэр бүлийн гишүүн, эсхүл харилцан хамааралтай этгээдээс бусад гуравдагч этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийг битүүмжлэх бол уг хөрөнгийг татварын албанд шилжүүлэх тухай гуравдагч этгээдэд бичгээр мэдэгдэнэ;

3.2.4.хөрөнгө шилжүүлэх үүрэг хүлээн авсан гуравдагч этгээдийн өртэй татвар төлөгчтэй байгуулсан түрээсийн гэрээ, хөрөнгө ашиглах, эсхүл орлого олох гэрээг цуцлах, цуцлахгүйгээр гурван сараар хязгаарлан хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох нөхцөлийн аль нэгийг сонгон хэрэгжүүлж болно;

3.2.5.татварын алба битүүмжилсэн хөрөнгийг өртэй татвар төлөгчид, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд ашиглах /орлого олох/ болон ашиглахыг зөвшөөрөхгүйгээр хадгалуулж болно;

3.2.6.татварын алба битүүмжилсэн хөрөнгийг өртэй татвар төлөгчид эсхүл тухайн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээдэд хадгалуулахгүй тохиолдолд зөөн тээвэрлэж, энэ тухай хөрөнгө битүүмжлэх актад тэмдэглэн гарын үсэг зуруулж, хуулбарыг тухайн хөрөнгийг эзэмшиж буй этгээдэд хүргүүлнэ;

3.3.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох үед бэлэн мөнгө илэрсэн үед тэмдэглэл үйлдэж, нэн даруй буюу 24 цагийн дотор татварын орлогын дансанд тушааж, тушаасан тухай баримтыг өртэй татвар төлөгчид өгнө. /Сангийн яамтай зөвших/

3.4.Татварын алба үнэт цаасыг битүүмжлэх актыг тухайн үнэт цаасыг бүртгэх, хадгалах, арилжих, төлбөр тооцоог гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд, Засгийн газрын үнэт цаасыг битүүмжлэх актыг Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу үнэт цаас гаргагчид битүүмжилснээс хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

3.5.Үнэт цаасны зах зээлийн оролцогч мэргэжлийн байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн битүүмжилсэн үнэт цаасны ханшийг тогтооно.

3.6.Үнэт цаасыг битүүмжилснээр тухайн үнэт цаасыг захиран зарцуулах, баталгаа гаргах, шаардлагатай бол ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарлана.

Дөрөв.Авлага битүүмжлэх

4.1.Авлагад цалин хөлс, ногдол ашиг, гуравдагч этгээдээс авах авлага буюу мөнгөн хөрөнгөд шилжүүлэх боломжтой хөрөнгийг нэхэмжлэх эрх, шаардах эрх, адилтгах бусад эх үүсвэр хамаарна.

4.2.Авлагын шинжтэй боловч хураах боломжгүй, мөнгөн хөрөнгөд шилжүүлэх ажиллагаа шаардлагатай зүйлс /түрээсийн авлага, хураах боломжгүй авлага гэх мэт/-ийг биет бус хөрөнгийн эрх гэж битүүмжилнэ.

4.3.Татварын өрийн хэмжээнээс хамаарч авлагыг бүрэн эсхүл хэсэгчлэн битүүмжлэх бөгөөд авлагыг битүүмжлэхдээ дараах журмыг баримтална:

4.3.1.Авлага битүүмжлэх ажиллагаа нь Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээр эхэлсэнд тооцно;

4.3.2.битүүмжлэх хугацаа нь битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээс эхлэн татварын өрийг бүрэн хураах хүртэл үргэлжилнэ;

4.3.3.цалин хөлсийг битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.6.6-г баримтална;

4.3.4.өртэй татвар төлөгч битүүмжлэлийн хугацаанд татварын өрийг бүрэн төлсөн бол татварын алба ажлын гурван өдрийн дотор гуравдагч этгээдэд авлагын битүүмжлэлийг цуцалсан тухай албан бичгээр мэдэгдэнэ.

4.4.Гуравдагч этгээд битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийн хуваарийн дагуу авлагын суутгал хийж, суутгал хийснээс хойш ажлын 3 өдрийн дотор татварын орлогын дансанд шилжүүлнэ.

4.5.Өртэй татвар төлөгч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан, болон бусад шалтгаанаар татварын өрийг суутгах боломжгүй болсон бол энэ тухай ажлын долоон өдрийн дотор татварын албанд мэдэгдэнэ.

4.6.Авлага битүүмжилсэн хугацаанд Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.7-д заасан үйлдэл хийхийг хориглоно.

Тав.Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах

5.1.Татварын алба татвар төлөгчийн банкн дахь дансыг битүүмжлэх замаар татварын өрийг гаргуулахдаа дараах журмыг баримтална:

5.1.1.банкн дахь данс гэдэгт татвар төлөгчийн арилжааны банканд нээлгэсэн хадгаламжийн болон харилцах данс хамаарна;

5.1.2.татвар төлөгч татварын өрийг Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол төлөөгүй татварын дүнгээр

хязгаарлан татвар төлөгчийн банканд дахь данснаас татварын өрийг гаргуулах тухай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг банканд хүргүүлнэ;

5.1.3.битүүмжлэх мэдэгдэх хуудсыг батлагдсан загвар, агуулгын дагуу үйлдэж, татвар төлөгчийн банканд дахь харилцах дансны зарлагын гүйлгээг бүрэн эсхүл хэсэгчлэн зогсоох тухай тусгаж, энэ тухайгаа татвар төлөгчид мэдэгдэнэ;

5.1.4.битүүмжлэх мэдэгдэх хуудсанд битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэж байгаа татварын албаны дарга гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна;

5.2.Битүүмжлэх хугацаа нь битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээс эхлэн татварын өрийг бүрэн хураах хүртэл хугацаанд үргэлжилнэ.

5.3.Банк дор дурдсан үүрэг хүлээнэ:

5.3.1.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан арилжааны банк нь Татварын ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.3-т заасныг хэрэгжүүлнэ; /Сангийн яамтай зөвших/

5.3.2.татвар төлөгчийн банканд дахь дансны үлдэгдэл нь битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан татварын өрийг бүрэн төлж хүрэлцэхгүй бол татвар төлөгчийн дансыг татварын өрийг бүрэн төлж дуусах хүртэл хугацаанд битүүмжилж, битүүмжилсэн дансанд орлого орсон тухай бүр шилжүүлнэ;

5.3.3.битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан шаардлагыг бүрэн биелүүлсэн бол татварын албанд тухай бүр мэдэгдэнэ;

5.4.Татварын алба энэ журмын 5.3.3-т заасан банкны мэдэгдлийг үндэслэн битүүмжлэх мэдэгдэх хуудсыг цуцалсан тухай ажлын 3 өдөрт багтаан банканд болон татвар төлөгчид мэдэгдэнэ.

5.5.Татвар төлөгч битүүмжлэлийн хугацаанд татварын өрийг үл маргах журмаас бусад хэлбэрээр төлсөн бол татварын алба татварын өр төлсөн хугацаанаас хойш ажлын 3 өдрийн дотор банканд болон татвар төлөгчид мэдэгдэж, битүүмжлэлийг цуцална.

Зургаа.Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх

6.1.Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 65 дугаар зүйл болон энэ журмын 2 дугаар зүйлд заасныг баримтлан хэрэгжүүлнэ.

6.2.Татварын алба үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилснээс хойш ажлын 3 өдөрт багтаан бүртгэх байгууллагад мэдэгдэж, битүүмжлэлийг бүртгүүлнэ.

Долоо.Биет бус хөрөнгө битүүмжлэх

7.1.Биет бус хөрөнгөд зохиогчийн эрх, түүнд хамаарах эрх, шинэ бүтээл, патент, технологи, бүтээгдэхүүний ашигтай загвар, барааны тэмдэг болон тэдгээртэй адилтгах бусад эрх болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан санхүүгийн хэрэгсэл хамаарна.

7.2.Биет бус хөрөнгийг битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 66 дугаар зүйл болон энэ журмын 2 дугаар зүйлд заасныг баримтлан хэрэгжүүлнэ.

7.3.Татварын алба биет бус хөрөнгийг битүүмжилснээс хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, битүүмжлэлийг бүртгүүлнэ.

7.4.Татварын алба гуравдагч этгээдийн ашиглаж байгаа биет бус хөрөнгийг битүүмжлэх тухай бүр гуравдагч этгээдэд битүүмжлэх хуудсыг хүргүүлж хэрэгжүүлнэ.

7.5.Хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшлийн хувь, бүх төрлийн хоршооны гишүүний өмчлөлийн хувь, хөдлөх хөрөнгийн хамтран эзэмшлийн хувь, түрээсийн эрх, патентын эрх, шинэ бүтээл оновчтой саналын эрх, зураг төслийн эрх ашиглах тусгай эрх, худалдааны тэмдэгт ашиглах тусгай эрх, хэвлэх эрх зэрэг гуравдагч

этгээдийн ашиглалт /гуравдагч өглөг бүхий этгээдтэй/-д байгаа биет бус хөрөнгийг Татварын ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.2-т заасны дагуу битүүмжилнэ.

7.6.Энэ журмын 8.5-д заасан эрхийг битүүмжлэхдээ бүртгэл хийлгэх шаардлагатай бол хөрөнгийн төрлөөс хамааруулан, битүүмжлэлийг холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

Найм.Битүүмжилсэн хөрөнгийг хадгалах, хамгаалах

8.1.Битүүмжилсэн, хураан авсан үл хөдлөх эд хөрөнгийг өртэй татвар төлөгч, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээдэд хадгалуулж болно.

8.2. Татварын улсын байцаагчийн битүүмжилсэн, хураан авсан хөдлөх эд хөрөнгийг татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүн, гэрээ байгуулсан бусад этгээдэд, эсхүл татварын албаны тусгай зориулалтын байранд хадгалуулж болно.

8.3.Энэ журмын 8.1, 8.2-т заасан этгээд хөрөнгийг хадгалж, түүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд татварын албаны зөвшөөрөлгүйгээр ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

8.4.Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийн шинж чанараас хамааран түүнийг ашиглах нь эд хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх, үрэгдүүлэх, гэмтээх эрсдэлтэй бол аливаа этгээдэд ашиглуулахыг хориглоно.

8.5.Битүүмжлэгдсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор зайлшгүй шаардлагатай тохиолдолд түүнийг хөдөлгөх, зөөж тээвэрлэхэд татварын албаны зөвшөөрөл шаардахгүй.

8.6.Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцагч этгээд /цаашид “Хадгалагч” гэх/ нь татвар төлөгчийн, эсхүл түүний гэр бүлийн гишүүн биш бол гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд Иргэний хуулийн 422 дугаар зүйлд заасан Хадгалалтын гэрээгээр зохицуулна.

8.7.Энэ журмын 3.1-т заасан мал, гэрийн тэжээвэр амьтан хадгалуулсны хөлсийг тэдгээрийг хадгалахад зарцуулсан зардлыг тооцож тухайн эд хөрөнгөөс бий болсон үр шимийг хасаж олгоно. **/Сангийн яамтай зөвших/**

8.8.Хадгалагч татварын албаны зөвшөөрөлгүйгээр хадгалуулсан эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, сольсон, үрэгдүүлсэн, гэмтээсэн, устгасан, нуусан, эд хөрөнгийн хэвийн байдлыг өөрчилсөн бол учирсан хохирлыг бүрэн хариуцна.

8.9.Үнэт цаасыг бүртгэх, хадгалах, арилжих, төлбөр төлөх, үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, Засгийн газрын үнэт цаас гаргагчид татвар төлөгчийн үнэт цаасыг битүүмжлэх тухай шийдвэрээр хязгаарлагдсан эрхийг хэрэгжүүлэх тухай татвар төлөгчийн аливаа шаардлагыг биелүүлэхийг хориглоно. Битүүмжлэх тухай шийдвэрийг хүлээн авмагц хязгаарлагдсан эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гүйлгээг даруй зогсооно.

Ес.Битүүмжлэлийг цуцлах

9.1.Татварын алба дараах тохиолдолд битүүмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн цуцална:

9.1.1.татвар төлөлт, суутган тооцох, татварын тайлан залруулснаар татварын дүнд өөрчлөлт орох зэргээс хамаарч, эсхүл бусад шалтгаанаар битүүмжлэлд хамаарах татварын өр бүрэн барагдсан;

9.1.2.битүүмжилсэн хөрөнгийн үнэ цэнэ нь тухайн битүүмжлэлд хамаарах татварын өр, хураах ажиллагааны зардал, битүүмжлэлд хамаарах татвараас давуу эрхтэй бусад татвар болон авлагын нийлбэр дүнд хүрэхгүй болсон;

9.1.3.битүүмжлэлд хамаарах татвар хэсэгчилэн төлөгдсөн, суутгагдсан, ногдол буурсан, битүүмжилсэн хөрөнгийн үнэ өссөн болон бусад шалтгаанаас тухайн үнэ нь битүүмжлэлд хамаарах татвараас давсан бусад татвар болон авлагын нийлбэрээс хэт их;

9.1.4.өртэй татвар төлөгч өөр битүүмжлэхэд тохиромжтой хөрөнгөөр сольсон, түүнийг нь битүүмжилсэн;

9.2.Битүүмжлэлийг цуцлахдаа өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ. Авлага, татвар төлөгчид өглөгтэй гуравдагч этгээд биет бус хөрөнгийн битүүмжлэлийг цуцлахдаа тэр тухайгаа зөвхөн өглөгтэй гуравдагч этгээдэд мэдэгдэж хэрэгжүүлнэ.

9.3.Үл хөдлөх эд хөрөнгө болон бусад хөрөнгийн битүүмжлэлийг цуцлахдаа энэ тухай холбогдох бүртгэх байгууллагад мэдэгдэж хэрэгжүүлнэ.

9.4.Татварын алба битүүмжлэлийг цуцалсан тухай энэ журмын 2.11-д заасан этгээдэд мэдэгдэнэ.



Монголын Татварын Алба

Маягт

БИТҮҮМЖЛЭЛИЙН ХУУДАС

___ оны ___ дугаар
сарын ___-ны өдөр

Дугаар___

/аймаг, нийслэл/

_____ аймаг /нийслэл/-ийн, сум /дүүрэг/-ийн _____ -ын татварын хэлтэстэй харилцагч _____ регистрийн дугаартай _____ татвар төлөгч та татварын улсын байцаагчийн _____ дугаартай мэдэгдэх хуудсанд заасан _____ төгрөг _____ мөнгөний татварын өрийг төлөөгүй тул Татварын ерөнхий хуулийн 65 дугаар зүйл, 66 дугаар зүйлийн 66.1-д заасныг үндэслэн:

1. Үл хөдлөх эд хөрөнгө /биет бус хөрөнгө/-ийн нэр _____
2. Байршил _____ -ийг

.....татварын албаны даргын оны сарын өдрийн тоот тушаалаар Татварын албаны мэдэлд авав.

Битүүмжлэлийн хуудас бичсэн:

Татварын албаны нэр: |_|_| _____

Тэмдэг

Татварын улсын байцаагч /...../
гарын үсэг нэр

Огноо: оны сарын өдөр





Монголын Татварын Алба

Маягт

ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ ТУХАЙ АКТ

___ оны ___ дугаар
сарын ___-ны өдөр

Дугаар___

/аймаг, нийслэл/

Эд хөрөнгө битүүмжилж буй газрын хаяг _____

_____ -т байрлах
_____ аймаг /нийслэл/-ийн _____ сум /дүүрэг/-ын _____ татварын
улсын байцаагч _____ би хөндлөнгийн гэрчээр

1. _____ ажилтай _____
_____ аймаг /нийслэл/-ийн сум /дүүрэг/-ын _____ баг /хороо/-
т амьдрах, регистрийн _____ дугаартай
_____ ны _____ -ыг,

2. _____ ажилтай _____
_____ аймаг /нийслэл/-ийн сум /дүүрэг/-ын _____ баг /хороо/-
т амьдрах, регистрийн _____ дугаартай _____ дугаартай
_____ ны _____ нарыг

оролцуулан _____ Татварын албаны _____ оны _____ сарын _____-ны
өдрийн _____ дугаар бүхий мэдэгдэх хуудсанд заасан өртэй татвар төлөгчийн
_____ төгрөг _____ мөнгөний татварын өрийг гаргуулахаар Татварын ерөнхий
хуулийн 60 дугаар зүйлийн 60.7.-д заасны дагуу доорхи жагсаалтад дурдсан _____ нэр
төрлийн эд хөрөнгийг битүүмжилж, захиран зарцуулах, ашиглах бусдад шилжүүлэх эрхийг
хориглов.

Битүүмжлэх ажиллагааны явцад _____ дугаартай лац /хэв, дардас/-аар лацадсан.

Битүүмжилсэн эд хөрөнгийг _____-ны /татвар төлөгч, түүний
гэр бүлийн гишүүн, гэрээ байгуулсан бусад этгээд/ хадгалалт, хамгаалалтад хүлээлгэн
өгч, битүүмжилсэн эд хөрөнгийг захиран зарцуулсан, үрэгдүүлсэн, шилжүүлсэн
тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 5, 15 дугаар бүлгийн 15.2-т
заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг сануулав.

Танилцсан: _____

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаанд төлбөр төлөгч, түүний төлөөлөгч, гэр бүлийн
гишүүд, бусад этгээд болох:

_____ нар байлцав.



БИТҮҮМЖИЛСЭН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр /хаяг, байршил, бүртгэлийн дугаар/	Элэгдэл, шинж байдал	Онцлох тэмдэг	Үнэлэх нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ

Эд хөрөнгийг битүүмжлэхэд байлцсан төлбөр төлөгч болон бусад этгээдээс гаргасан санал, хүсэлтийн агуулга, түүнийг татварын албанаас шийдвэрлэсэн байдал _____

Төлбөр төлөгч _____-нд шүүхийн шийдвэрт заасан үүргийг _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор биелүүлэх хугацаа тогтоож, үүргийг биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх ажиллагаа явуулахыг мэдэгдэв.

ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ АКТ
ҮЙЛДСЭН:

Татварын улсын байцаагч /...../
гарын үсэг нэр

ХӨНДЛӨНГИЙН ГЭРЧ:

..... /...../
гарын үсэг нэр

..... /...../
гарын үсэг нэр

БАЙЛЦСАН ХҮН:

..... /...../
гарын үсэг нэр

БИТҮҮМЖИЛСЭН ЭД ХӨРӨНГИЙГ
ХАДГАЛАГЧ

..... /...../
гарын үсэг нэр





Монголын Татварын Алба

Маягт

БИТҮҮМЖЛЭХ ТУХАЙ АКТ

20 оны дугаар
сарын-ний өдөр

Дугаар

.....
хот /сум/

1. Татварын албаны нэр | | | _____
2. Татварын улсын байцаагчийн нэр _____
3. Татвар төлөгчийн овог, нэр _____
4. Татвар төлөгчийн регистрийн дугаар | | | | | | | | | | | _____
5. Татвар төлөгчийн нэр _____
6. Татвар төлөгчийн дугаар | | | | | | | | | | | _____
7. Татвар төлөгчийн хаяг _____
8. Битүүмжлэлд хамаарах хөрөнгийн:
 - а/ нэр: _____
 - б/ байршил: _____
 - в/ битүүмжлэх болсон үндэслэл: _____

Уг хөрөнгийг оны ...-р сарын ...-ний өдөр битүүмжлэв.

Акт үйлдсэн:

Татварын улсын байцаагч /...../
гарын үсэг нэр

Акттай танилцсан:

.....-ны ажилтан /...../
гарын үсэг нэр





Монголын Татварын Алба

Маягт

ХӨРӨНГӨ БИТҮҮМЖИЛСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

20 оны дугаар
сарын-ний өдөр

Дугаар

.....
хот /сум/

1. Татварын албаны нэр
2. Татварын улсын байцаагчийн нэр
3. Татвар төлөгчийн овог, нэр
4. Татвар төлөгчийн регистрийн дугаар
5. Татвар төлөгчийн нэр
6. Татвар төлөгчийн дугаар
7. Татвар төлөгчийн хаяг
8. Битүүмжлэлд хамаарах хөрөнгийн:
 - а/ нэр:
 - б/ байршил:
 - в/ битүүмжлэх болсон үндэслэл:

Татварын Ерөнхий хуулийн..... дугаар зүйлийн заалтыг үндэслэн битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэв.

Битүүмжлэх ажиллагаанд дараах этгээдүүд оролцов:

1. Уг зүйлийг эзэмшигч /татвар төлөгчийн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/
2. Хөндлөнгийн гэрч / овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/
3. Хөндлөнгийн гэрч / овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/
4. Нутгийн захиргааны төлөөлөгч / овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/

Битүүмжлэх ажиллагаанд оролцогч хөндлөнгийн гэрч нарт битүүмжлэх үйл ажиллагааг эхнээс нь дуустал анхааралтай ажиглан харж, битүүмжлэх ажиллагааны талаар хожим ямар нэгэн гомдол санал, маргаан гарахад битүүмжлэх ажиллагааны талаар шударгаар үнэн зөв гэрчлэх үүрэгтэйгээр оролцож байгаа талаар танилцуулсан болно.

Хөндлөнгийн гэрчийн гарын үсэг: 1. /...../
2. /...../

Битүүмжлэх ажиллагааг 20.... оны....дугаар сарын ...-ний өдрийнцагт.....минутаас эхлэн 20 оны ...дугаар сарын ...-ний өдрийн ...цаг...минут хүртэл хийв.





Монголын Татварын Алба

Маягт

БИТҮҮМЖЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ:

/ тодорхой, дэлгэрэнгүй бичих/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

БИТҮҮМЖИЛСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ:

№	Хөрөнгийн нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Чанар	Нэг бүрийн үнэ /төг/	Бүгд үнэ /төг/	Тайлбар

..... овогтой- д битүүмжилсэн хөрөнгийг бүрэн бүтэн байлгах, татварын албаны зөвшөөрөлгүйгээр лац, ломбо, түгжээг хөдөлгөх, битүүмжилсэн хөрөнгийг ашиглах, үрэгдүүлэх, бусдад худалдах, шилжүүлэхгүй байх тухай танилцуулав.

Битүүмжлэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцсан этгээдүүдийн гарын үсэг, санал:

1.
2.
3.
4.

Тэмдэглэл хөтөлсөн
татварын улсын байцаагч:

..... / тэмдэг, гарын үсэг /





Монголын Татварын Алба

Маягт

МЭДЭГДЭХ ХУУДАС

Дугаар

Мэдэгдэх хуудсыг хүлээн авагч: байгууллагын даргын
/үнэт цаас борлуулах эрх бүхий этгээд/

овог, нэр, регистрийн дугаар

Татварын ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн заалтуудыг үндэслэн
..... байгууллагын эзэмшиж буй /үнэт
цаасны нэр/ -аас татварын өрийг гаргуулах зорилгоор битүүмжлэхээршийдвэрлэснийг
мэдэгдэж байна.

Үнэт цаас битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэх тухай татвар төлөгчид урьдчилан
мэдэгдсэн дугаартай мэдэгдэх хуудсыг хүлээн авсан татвар төлөгчийн
тэмдэглэл, мэдэгдэх хуудас гардуулсан тухай татварын улсын байцаагчийн тэмдэглэлийг
хавсаргав.

Үнэт цаас битүүмжлэх ажиллагааг гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруутай албан
тушаалтанд Татварын ерөнхий хуулийн-д заасан хариуцлага хүлээлгэх болно.

Мэдэгдэх хуудас бичсэн:

Татварын албаны нэр: |_|_| _____

Тэмдэг

Татварын албаны дарга /...../
гарын үсэг нэр

Огноо: оны сарын өдөр

.....
/татварын албанд үлдэх хэсэг/

Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан тухай тэмдэглэл

..... байгууллагын дарга /хувь хүн/ овогтой
..... нь татварын албанаас ирүүлсэн дугаартай мэдэгдэх
хуудсыг хүлээн авсан.

Хүлээн авсан этгээдийн гарын үсэг:

Огноо:





Монголын Татварын Алба

Маягт

БИТҮҮМЖЛЭХ МЭДЭГДЭХ ХУУДАС

20 оны дугаар Дугаар
сарын-ний өдөр
аймаг /нийслэл/
.....-нд

..... аймаг /нийслэл/-ийн, сум /дүүрэг/-ийн -ын татварын
улсын байцаагч би Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр
зүйлийн 64.1, 64.6.1, 66 дугаар зүйлийн 66.2.1-д заасныг үндэслэн:

1. регистрийн дугаартай татвар төлөгчийн танай
байгууллага /иргэн/-аас авах..... төрлийн
авлагын.....төгрөг..... мөнгөнийг татварын албаны
.....тоот дансанд шилжүүлэхийг мэдэгдэж байна.
2. Авлагаас татварын өрийг барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэх тухай татвар
төлөгчид урьдчилан мэдэгдсэн дугаартай мэдэгдэх хуудсыг хүлээн
авсан татвар төлөгчийн тэмдэглэл, мэдэгдэх хуудас гардуулсан тухай татварын
улсын байцаагчийн тэмдэглэлийг хавсаргав.
3. Танд энэхүү мэдэгдэх хуудасны хавсралтад заасан татварын өрийг холбогдох
дансанд шилжүүлэх, татварын өрийг бүрэн барагдуулахыг үүрэг болгож байна.
4. Татварын ерөнхий хуулийн 64, 66.2 дугаар зүйлд заасан Авлага болон биет бус
хөрөнгийг битүүмжлэн татварын өрийг барагдуулах ажиллагааг гүйцэтгээгүй
тохиолдолд гэм буруутай албан тушаалтанд Татварын ерөнхий хуулийн-д
заасан хариуцлага хүлээлгэх болно.

Мэдэгдэх хуудас бичсэн:

Татварын албаны нэр: |_|_|
Тэмдэг
Татварын албаны дарга /...../
гарын үсэг нэр

Огноо: оны сарын өдөр

.....
/татварын албанд үлдэх хэсэг/

Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан тухай тэмдэглэл

..... байгууллагын дарга /хувь хүн/ овогтой
..... нь татварын албанаас ирүүлсэн дугаартай мэдэгдэх
хуудсыг хүлээн авч, мэдэгдэх хуудсанд заагдсан татварын өрийг Татварын ерөнхий
хуулийн-д заасны дагуу -д өгөх өглөгөөс суутган төсвийн
..... дугаарын дансанд татварын өрийг бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд
шилжүүлэх үүрэг хүлээж байна.

Хүлээн авсан этгээдийн гарын үсэг:

Огноо: оны сарын өдөр





Монголын Татварын Алба

Маягт

БИТҮҮМЖЛЭХ МЭДЭГДЭХ ХУУДАС

20 оны дугаар Дугаар
сарын-ний өдөр аймаг /нийслэл/
.....-нд

..... аймаг /нийслэл/-ийн, сум /дүүрэг/-ийн хэлтэс/-ын
Татварын улсын байцаагч би татварын
албаны _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн _____ мэдэгдэх
хуудастай өртэй татвар төлөгчийн Татварын ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1,
Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 1.4 дэх заалтуудыг
үндэслэн:

1.Татвар төлөгчийн _____-ны харилцах болон
хадгаламжийн _____ тоот дансны
зарлагын гүйлгээг зогсоож, татварын өрийн тооцооллын хуудсанд заасан төлбөр
_____ төгрөг _____ мөнгийг татвар төлөгчийн дансан дахь мөнгөн
хөрөнгөөс татварын албаны _____ тоот дансанд шилжүүлэхийг мэдэгдэж
байна.

2.Татварын ерөнхий хуулийн 63 дугаар зүйлд заасан Үл маргах журмаар татварын
өрийг барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэх тухай /татвар төлөгчид урьдчилан мэдэгдсэн
..... дугаартай мэдэгдэх хуудсыг хүлээн авсан татвар төлөгчийн тэмдэглэл/
мэдэгдэх хуудас гардуулсан тухай татварын улсын байцаагчийн тэмдэглэлийг хавсаргав.

3.Танд энэхүү мэдэгдэх хуудасны хавсралтад заасан татварын өрийг харилцагчийн
данснаас түүнийг зөвшөөрсөн эсэхээс үл хамааран төсвийн орлогын холбогдох дансанд
Татварын ерөнхий хуулийн 63.1.3 болон 63.1.4 дэх заалтуудад заасны дагуу шилжүүлэх,
татварын өрийг бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд харилцагчийн дансны зарлагын
гүйлгээг бүрэн зогсоохыг үүрэг болгож байна.

4.Өр барагдуулах ажиллагааг гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруутай албан
тушаалтанд Татварын ерөнхий хуулийн-д заасан хариуцлага хүлээлгэх болно.

Битүүмжлэх мэдэгдэх хуудас бичсэн:

Татварын албаны нэр: |_|_| _____

Тэмдэг

Татварын албаны дарга /...../
гарын үсэг нэр

Огноо: оны сарын өдөр

.....
/татварын албанд үлдэх хэсэг/

Битүүмжлэх мэдэгдэх хуудсыг хүлээн авсан тухай тэмдэглэл

..... банкны салбарын захирал
овогтой нь татварын албанаас ирүүлсэн
дугаартай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг хүлээн авч, мэдэгдэх хуудсанд заагдсан
татварын өрийг Татварын ерөнхий хуулийн-д заасны дагуу харилцагчийн
данснаас дугаарын дансанд шилжүүлэх, харилцагчийн данснаас
төлөх зарлагын гүйлгээг татварын өрийг бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд бүрэн
зогсоох арга хэмжээ авах үүрэг хүлээж байна.

Хүлээн авсан этгээдийн гарын үсэг:



ТӨСӨЛ
/2019.08.18-ны өдөр/

Огноо: оны сарын өдөр



Татварын өрийн тооцоолол
Мэдэгдэх хуудасны дугаар

Өглөгтэй этгээдэд хүргүүлэх хэсэг

/төгрөгөөр/

Татварын албаны нэр		Татварын өрийн тооцоолол							
Банкны нэр	Дансны дугаар	Татварын өр				Үндэслэл	Тайлант он	Тайлант хугацаа	Төлбөл зохих татварын өр
		Татвар	хүү	Торгууль	Алданги				
Төлбөл зохих татварын өрийн нийт дүн									

Тооцоолол хийсэн:

Татварын улсын байцаагч /...../

Тэмдэг



Татварын өрийн тооцоолол
Мэдэгдэх хуудасны дугаар...

Татварын албанд үлдэх хэсэг

/төгрөгөөр/

Татварын албаны нэр		Татварын өрийн тооцоолол							
Банкны нэр	Дансны дугаар	Татварын өр				Үндэслэл	Тайлант он	Тайлант хугацаа	Төлбөл зохих татварын өр
		Татвар	хүү	Торгууль	Алданги				
Төлбөл зохих татварын өрийн нийт дүн									

Тооцоолол хийсэн:

Татварын улсын байцаагч /..... /

Тэмдэг





Монголын Татварын Алба

Маягт

МЭДЭГДЭХ ХУУДАС

Дугаар

Мэдэгдэх хуудсыг хүлээн авагч:банкны салбар

Татварын ерөнхий хуулийн 55, 60.1 болон 63 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 1.4 дэх заалтуудыг үндэслэн танай банкны харилцагч -ийн дугаарын

/өртэй татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар/

харилцах данснаас татварын өрийг үл маргах журмаар гаргуулан /зарлагын гүйлгээг зогсоож/ татварын өр болох төгрөгийг банкин дахь төсвийн орлогын дугаарын дансанд шилжүүлнэ үү.

Үл маргах журмаар татварын өрийг барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэх тухай татвар төлөгчид урьдчилан мэдэгдсэн дугаартай мэдэгдэх хуудсыг хүлээн авсан татвар төлөгчийн тэмдэглэл/ мэдэгдэх хуудас гардуулсан тухай татварын улсын байцаагчийн тэмдэглэлийг хавсаргав.

Танд энэхүү мэдэгдэх хуудасны хавсралтад заасан татварын өрийг харилцагчийн данснаас түүнийг зөвшөөрсөн эсэхээс үл хамааран төсвийн орлогын холбогдох дансанд Татварын ерөнхий хуулийн 63.1.3 болон 63.1.4 дэх заалтуудад заасны дагуу шилжүүлэх, татварын өрийг бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд харилцагчийн дансны зарлагын гүйлгээг бүрэн зогсоохыг үүрэг болгож байна.

Үл маргах журмаар татварын өрийг барагдуулах ажиллагааг гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруутай албан тушаалтанд Татварын ерөнхий хуулийн-д заасан хариуцлага хүлээлгэх болно.

Мэдэгдэх хуудас бичсэн:

Татварын албаны нэр: |_|_| _____

Тэмдэг

Татварын албаны дарга /...../
гарын үсэг нэр

Огноо: оны сарын өдөр

.....
/татварын албанд үлдэх хэсэг/

Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан тухай тэмдэглэл

..... банкны салбарын захирал
овогтой нь татварын албанаас ирүүлсэн
дугаартай мэдэгдэх хуудсыг хүлээн авч, мэдэгдэх хуудсанд заагдсан татварын өрийг
Татварын ерөнхий хуулийн-д заасны дагуу харилцагчийн данснаас
төсвийн дугаарын дансанд шилжүүлэх, харилцагчийн данснаас төлөх зарлагын
гүйлгээг татварын өрийг бүрэн барагдуулах хүртэлх хугацаанд бүрэн зогсоох арга хэмжээ
авах үүрэг хүлээж байна.

Хүлээн авсан этгээдийн гарын үсэг:

Огноо:



Татварын өрийн тооцоолол
Мэдэгдэх хуудасны дугаар

Банкинд хүргүүлэх хэсэг

/төгрөгөөр/

Татварын албаны нэр		Татварын өрийн тооцоолол							
Банкны нэр	Дансны дугаар	Татварын өр				Үндэслэл	Тайлант он	Тайлант хугацаа	Төлбөл зохих татварын өр
		Татвар	хүү	Торгууль	Алданги				
Төлбөл зохих татварын өрийн нийт дүн									

Тооцоолол хийсэн

Татварын улсын байцаагч /...../

Тэмдэг



Татварын өрийн тооцоолол
Мэдэгдэх хуудасны дугаар...

Татварын албанд үлдэх хэсэг

/төгрөгөөр/

Татварын албаны нэр		Татварын өрийн тооцоолол							
Банкны нэр	Дансны дугаар	Татварын өр				Үндэслэл	Тайлант он	Тайлант хугацаа	Төлбөл зохих татварын өр
		Татвар	ХҮҮ	Торгууль	Алданги				
Төлбөл зохих татварын өрийн нийт дүн									

Тооцоолол хийсэн Татварын улсын байцаагч /..... /

Тэмдэг





Монголын Татварын Алба

Маягт

ХӨРӨНГИЙН БИТҮҮМЖЛЭЛИЙГ ЦУЦЛАХ АКТ

1. Татварын албаны нэр |__| _____
2. Татварын улсын байцаагчийн нэр _____
3. Татвар төлөгчийн овог, нэр _____
4. Татвар төлөгчийн регистрийн дугаар |__|__|__|__|__|__|__|__|__|__|__|__|
5. Татвар төлөгчийн нэр _____
6. Татвар төлөгчийн дугаар |__|__|__|__|__|__|__|__|__|__|__|__|
7. Татвар төлөгчийн хаяг _____
8. Битүүмжлэлд хамаарах хөрөнгө /үнэт цаас, авлага данс/- ийн:

а/ нэр: _____

б/ байршил: _____

в/ битүүмжлэлийг цуцлах үндэслэл: _____

Татварын улсын байцаагчийн ... оны –р сарын ...-ний өдрийн ... тоот актаар хийсэн хөрөнгийн битүүмжлэлийг 20 ... оны ... -р сарын –ний өдрийн ... цагт цуцлав.

Битүүмжилсэн хөрөнгийг хөрөнгө битүүмжлэх тухай ... тоот актын “Хөрөнгө битүүмжилсэн тухай тэмдэглэл”-д тусгасан жагсаалтын дагуу 20... оны ...-р сарын ...-ний өдрийн цагт эзэмшигч-д хүлээлгэн өгөв.

Акт үйлдсэн:

Татварын улсын байцаагч /...../
гарын үсэг нэр

Акттай танилцсан:

Хөрөнгө эзэмшигч /...../
гарын үсэг нэр





Монголын Татварын Алба

Маягт

ХӨРӨНГИЙН БИТҮҮМЖЛЭЛИЙГ ЦУЦАЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

20 оны дугаар
сарын-ний өдөр

Дугаар

.....
хот /сум/

- | | |
|---------------------------------------|-----------------------------|
| 1. Татварын албаны нэр | _ _____ |
| 2. Татварын улсын байцаагчийн нэр | _____ |
| 3. Татвар төлөгчийн овог, нэр | _____ |
| 4. Татвар төлөгчийн регистрийн дугаар | _ _ _ _ _ _ _ _ _ _ _ _ _ _ |
| 5. Татвар төлөгчийн нэр | _____ |
| 6. Татвар төлөгчийн дугаар | _ _ _ _ _ _ _ _ _ _ _ _ _ _ |
| 7. Татвар төлөгчийн хаяг | _____ |
| 8. Битүүмжлэлд хамаарах хөрөнгийн: | _____ |

а/ нэр:

б/ байршил:

в/ битүүмжлэлийг цуцлах үндэслэл:

Татварын улсын байцаагчийн ... оны –р сарын ...-ний өдрийн ... тоот актаар хийсэн хөрөнгийн битүүмжлэлийг 20 ... оны ... -р сарын –ний өдрийн ... цагт цуцлав.

Битүүмжлэлийг цуцлах ажиллагаанд дараах этгээдүүд оролцов:

1. Уг зүйлийг эзэмшигч /татвар төлөгчийн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/

2. Хөндлөнгийн гэрч / овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/

3. Хөндлөнгийн гэрч / овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/

4. Нутгийн захиргааны төлөөлөгч / овог, нэр, эрхэлдэг ажил, гэрийн хаяг/

Битүүмжлэлийг цуцлах ажиллагаанд оролцогч хөндлөнгийн гэрч нарт битүүмжлэлийг цуцлах үйл ажиллагааг эхнээс нь дуустал анхааралтай ажиглан харж, битүүмжлэх ажиллагааны талаар хожим ямар нэгэн гомдол санал, маргаан гарахад битүүмжлэлийг цуцлах ажиллагааны талаар шударгаар үнэн зөв гэрчлэх үүрэгтэйгээр оролцож байгаа талаар танилцуулсан болно.

Хөндлөнгийн гэрчийн гарын үсэг: 1. /...../
2. /...../

Битүүмжлэлийг цуцлах ажиллагааг 20.... оны....дугаар сарын ...-ний өдрийн ...цагт.....минутаас эхлэн 20 оны ...дугаар сарын ...-ний өдрийн ...цаг...минут хүртэл хийв.





Монголын Татварын Алба

Маягт

БИТҮҮМЖЛЭЛИЙГ ЦУЦЛАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ: / тодорхой, дэлгэрэнгүй бичих/

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

БИТҮҮМЖЛЭЛИЙГ НЬ ЦУЦАЛСАН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ:

№	Хөрөнгийн нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Чанар	Нэг бүрийн үнэ /төг/	Бүгд үнэ /төг/	Тайлбар

Битүүмжлэлийг цуцлах ажиллагааны тэмдэглэлтэй танилцсан этгээдүүдийн гарын үсэг, санал:

1.
2.
3.
4.

Тэмдэглэл хөтөлсөн

Татварын улсын байцаагч /...../
гарын үсэг нэр

